

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛАЛТ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Н.Азжаргал

ДХИС-ийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа

Товч агуулга: Монгол Улсын Үндэсний язгуур ашиг сонирхол, хилийн аюулгүй байдлыг хангах, хил цэргийн байгуулалтыг боловсронгуй болгоход нөлөөлөх хүчин зүйлийг задлан шинжилж, дүгнэлт гарган, цаашдын бодлого чиглэлээ тодорхойлох, санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Улсын хил хамгаалалт, цэргийн байгуулалт, хилийн цэргийн байгуулалт, байгуулалтын онол.

Оршил. Улс орны оршин тогтнох, тусгаар тогтнолоо баталгаатай хангах үндэс нь тухайн улсын хил хязгаар, түүний аюулгүй байдал байдаг.

Дэлхий нийтэд өрнөж байгаа даяаршил, нийгэм улс төрийн байдал, манай орны гадаад, дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хилийн хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандах шаардлагатай байгааг улам бүр харуулж байна.

Улсын хилийн асуудал нь олон улсын конвенц, гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хуулиудаар зохицуулагддаг, олон улсын шинж төлөв давамгайлсан улс төр-дипломат, гэрээ эрх зүй, тагнуул, цэрэг, техникийн болон дэглэм сахиулах арга хэмжээнүүдийг цогцоор хэрэгжүүлдэг онцлогтой. Үүгээрээ хил хамгаалах байгууллагын үүрэг, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гүйцэтгэдэг үүргээс ялгагддаг.

Онол, үзэл баримтлалуудад батлан хамгаалах бодлого, цэргийн байгуулалт, зэвсэгт хүчний байгуулалт хооронд онол, практик, тэдгээрийн зүй тогтол, мөн чанар, онцлог заримдаа ойролцоо, ижил төстэй ойлголт боловч

2015 онд батлагдсан "Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичигт тусгагдсан төрийн цэргийн байгууллага нь нэгдмэл байх тухай, цэргийн байгууллага нь зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ гэж заасан.

Дэлхийн улс орнуудын цэргийн байгуулалт нь тухайн улс орны улс төрийн бодлого, нийгэм-эдийн засгийн чадавх, нөөц, шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийн түвшнээс хамаарч харилцан адилгүй байна.

Нэг. Цэргийн байгуулалтын онолын үндэс:

Аливаа улс гүрний Батлан хамгаалах бодлого, стратеги нь улс төрийн хөгжлөөр тэтгэгдэж, цэргийн байгуулалтаар (Зэвсэгт хүчин болон бусад цэрэг) илэрхийлэгдэж байдаг болно. Ийм учраас дэлхийн улс орнуудын батлан хамгаалах бодлого, стратеги нь тухайн улс орны улс төрийн бодлого, эдийн засгийн чадавх, нөөц, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшнээс хамаарч харилцан адилгүй байдаг.

"Цэргийн байгуулалт" нь "Зэвсэгт хүчнийг байгуулах онол-практикийг өөртөө агуулсан цэргийн

хэргийн нэг хэсэг, өөрөөр хэлбэл, өөрийн орныхоо батлан хамгаалах чадамжийг хангах, цэргийн хүчин чадлыг бэхжүүлэх талаар тухайн улс төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй харилцан уялдаа холбоо бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй бөгөөд цэргийн арга хэмжээний цогц асуудал болно.¹

Ингэхдээ цэргийн байгуулалтын онол нь цэргийн байгуулалтыг бүрдүүлэх, шинэчлэх, мөн чанар, зүй тогтол, зарчим, арга хэлбэрийн тухай шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо, практик нь тайван болон дайн бүхий үед, онцгой нөхцөлд зэвсэгт хүчин, төрөл цэрэг, тусгай хүчин (алба)-ны харилцааг бий болгох, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, зэвсэг, техникийн хангалт болон бусад шаардлагатай материал хангалтыг багтаана.

Зэвсэгт хүчин нь тайван цагт хуурай замын, агаарын цэрэг, барилга инженерийн цэрэг, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний /сүүлд нэмэгдсэн/ цэргээс бүрдэнэ. Дайны байдлын үед зэвсэгт хүчинд хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын цэрэг нэгдэж үүрэг гүйцэтгэнэ гэж хуульчилсан нь цэргийн байгуулалтын онол, практикийн асуудлыг өргөн хүрээнд авч үзэхийг шаардаж байна.

Цэргийн байгуулалтын талаарх онол нь "Цэргийн байгуулалтын ерөнхий онол", түүнд үндэслэсэн цэргийн байгуулалтын бие даасан онолуудаас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл цэргийн байгуулалт нь:

- Зэвсэгт хүчний байгуулалт

- Хилийн цэргийн байгуулалт
- Дотоодын цэргийн байгуулалт
- Онцгой байдлын цэргийн байгуулалтаас бүрдэнэ гэж үзэж байгаа болно.

Тэдгээрийг байгуулах, хөгжүүлэх, бэхжүүлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн бусад арга хэмжээний цогцыг цэргийн байгуулалт гэнэ гэх бөгөөд цэргийн байгуулалтыг бүрдүүлэгч бусад байгууллагууд нь өөр өөрсдийн онцлогт зохицсон байгуулалтын асуудлуудаар цэргийн байгуулалтын үндсэн шаардлагыг баяжуулж байна.

Хилийн цэргийн байгуулалтын онол нь ердийн болон хилийн цагийн байдал хүндэрсэн үед хилийн цэрэг (хил хамгаалах байгууллага) үүргээ биелүүлэх хамгийн боловсронгуй зохион байгуулалтын бүтэц, эдгээр асуудлыг шийдвэрлэхэд бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техникээр хангах, бэлтгэл хүч болон цэргийн боловсон хүчин бэлтгэх, байршуулах зэрэг асуудлыг судалдаг шинжлэх ухааны мэдлэгийн цогц мөн.²

Дараах гурван үндэслэлээр хилийн цэргийн байгуулалтын бие даасан онол бий болох нөхцөл бүрэлдсэн гэж үздэг:

1. Тайван (ердийн) болон дайны үед (хилийн цагийн байдал хүндэрсэн) шийдвэрлэх асуудлуудын буюу хил хамгаалалтын онцлог (эдгээр нь хилийн цэргийн бүтэц зохион байгуулалт, зэвсэглэлд шууд нөлөөлдөг);³

¹ Ц.Дашзэвэг, Ш.Паламдорж, Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014. 168 дахь тал.

² Н.Наранжамц, Улсын хил хамгаалалтын онол-практикийн үндсэн асуудлууд. УБ., 2008. 15 дахь тал.

³ Энхтөр А. Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтын онол практикийн асуудал УБ., 2022 он. 54 дэх тал

2. Ашиглалт, зориулалтаас хамаарсан хилийн цэргийн зохион байгуулалтын бүтцийн онцлог шинж;

3. Цэргийн хэргийн хөгжлийн өндөр хурдац, зэвсэгт хүчин, хилийн цэргийн хооронд зарчмын ялгаа бий болгосон явдал.

Гэвч хилийн цэргийн байгуулалтын онол нь Зэвсэгт хүчний байгуулалтын онолын нэлээд асуудлыг удирдлага болгодог байна.

Хилийн цэргийн байгуулалтын онолд хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд бэлтгэх, хил хамгаалах байгууллага, хилийн цэргийг байгуулах, шинэ нэгж бий болгох, бэхжүүлэх, офицер, боловсон хүчнийг бэлтгэх, зохион байгуулалтын бүтцийг тогтоох, бүрдүүлэх, зэвсэглэл, техникээр хангах зэрэг асуудлууд хамаарна.

Хоёр.Хилийн цэргийн байгуулалтын түүхэн уламжлал:

Монгол Улс нь эртний түүх бүхий улс бөгөөд үүсэн бий болсон, оршин байх бүхий л түүхийн явцад цэрэг, зэвсгийн хүчийг бий болгох, хүчирхэгжин мандаж, хөгжүүлж, дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөөр ирсэн билээ.

1990-ээд оноос өмнө Монголын түүх, тэр дундаа Монгол цэргийн түүх нь үндсэндээ хаагдмал, хязгаарлагдмал нөхцөлд судлагдан ирсэн бөгөөд ардчилсан шинэ нийгэмд шилжсэн үеэс эхлэн эртний Монголын түүх, түүний салшгүй хэсэг болсон цэргийн түүх судлал эрчимтэй хөгжиж байна

Хилийн цэргийн байгуулалтын түүх, уламжлал, шинэчлэл Монгол Улсын Хилийн цэрэг нь олон зууны өмнө үүсэж бий болсон хэдий ч орчин

үеийн хилийн цэрэг үүссэн хугацааг 1933 оноос авч үздэг.

Монгол Улсын эртний хил хамгаалалт нь¹:

Нийтийн тооллын өмнөх 209 оноос 95 оныг хүртэл манай улсын нутаг дэвсгэрт Хүннү хэмээх улсыг Модун хаан байгуулсан нь одоогийн Монгол нутагт байгуулагдсан анхны төрт улс байсан.

Их Монгол Улсын үед Хүннү гүрнээс улбаатай цэрэг-засаг, захиргааны орон нутгийн нэгжүүд, хил хязгаараа сахин хамгаалах үүргийг гүйцэтгэж байсан энэ тогтолцоо Монголын Эзэнт гүрний үед улам баяжиж боловсронгуй болсоор XIX зуунтай золгосон түүхтэй.

Монгол Улсын хилийг хамгаалж ирсэн түүхийг авч үзвэл дараах түүхэн үечлэл, он дараалал гарч байна. Үүнд:

-Манж Чин Улсын эрхшээлд байсан үеийн хил хамгаалалт (1661-1911 он);

-Олноо өргөгдсөн Богд хаант улсын үеийн хил хамгаалалт (1911-1920 он);

-Хилийн цэргийг байгуулж, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээ авсан жилүүд² (1921-1933 он);

1922 оны хавар төвийн цэргийн ангиудаас 750, Сэцэн хан аймаг дахь цэргийн ангиудаас 750, бүгд 1500 цэргийг дорнод хязгаарт байрлуулж, хязгаарын цэргийн ангиудыг хязгаарын цэргийн тусгай морин цэргийн хороо, дивизион, сумангийн зохион байгуулалттай байхаар орон тоо, зэвсэглэлийг тогтоож, хилийн тусгай ангиуд нь Хэрлэнгийн Гурванбаян, Тамсаг, Егүзэрийн хийд, Дарьганга,

¹ Монгол Улсын хил хамгаалалтын түүх I боть. УБ., 2008. 28 дахь тал.

² Монгол Улсын хил хамгаалалтын түүх II боть. УБ., 2008. 30 дахь тал.

Замын-Үүд, Сулинхээрт нийт 6 анги байсан бөгөөд анги бүр 3 комендатуртай, 1 комендатурт 6-8 харуул байв.

-Хилийн цэргийн байгуулалтыг бэхжүүлж, хөгжүүлэхэд олон чухал арга хэмжээ авсан жилүүд (1933-1953);

- Ховд-Үрэмчийн чиглэлд: Монгол Улсын өмнөд, баруун чиглэлийн 3000 гаруй км хэсгийг 2 ангийн хүчээр хамгаалж байсан учир БНМАУ-ын Сайд нарын 1933 оны 1 дүгээр сарын 20-ны 3 дугаар тогтоолоор Хязгаарын цэргийг Дотоодыг хамгаалах газрын харьяанд байгуулж, уг шийдвэрийн үндсэн дээр Цэргийн яамны Улаанбаатар хот болон орон нутгийн цэргийн ангиудаас зарим анги, салбаруудыг хязгаарын цэргийн мэдэлд шилжүүлэн өгсөн. Ийнхүү 1500 км хэсгийг 2 анги, 3 комендатур, 20 гаруй харуул, 800 орчим хүнээр хамгаалж байж, түүн дээр дахин 1 отряд, 3 комендатур нэмж, 1700 орчим хүн нэмэгдсэн байна.

- Хязгаарын цэргийг татан буулгасан үеийн хамгаалалт (1953-1966 он);
- Хил хамгаалалтыг бэхжүүлэхээр авсан зарим арга хэмжээ (1966-1990 он);
- Өөрчлөлт шинэчлэлтийн үеийн хилийн цэрэг (1990-2000 он);
- XXI зууны эхэн үеийн хилийн цэрэг (2000-2010 он);
- Өнөөгийн хил хамгаалалтын үе (2010 оноос одоог хүртэл);

Үүний зэрэгцээ Хил хамгаалах байгууллагын бүтэц, зохион байгуулалт тухайн цаг үе, нийгмийн байдалтай уялдан:

- Хязгаарын цэрэг (1933-1953 он);
- Батлан хамгаалах яам болон Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах хэрэг эрхлэх яамны

Хилийн ба Дотоодын цэргийн аюулаас хамгаалах хэлтэс (1953-1964 он);

- Батлан хамгаалах яамны Хилийн ба дотоодын цэргийн хэрэг эрхлэх хэлтэс (1964-1967 он);
- Нийгмийг аюулаас хамгаалах яамны Хязгаарын ба дотоодын цэргийн хэрэг эрхлэх газар (1968-1979 он);
- Хилийн ба Дотоодын цэргийн удирдах ерөнхий газар (1979-1990 он);
- Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын Хилийн цэргийн удирдах газар (1990-1993 он);
- Хилийн цэргийн удирдах газар, Засгийн газрын дэд бүтцийн агентлаг (1993-1996 он);
- Батлан хамгаалах яамны харьяа Засгийн газрын тохируулагч агентлаг, Хилийн цэргийн удирдах газар (1996-2000 он);
- 2000 оноос Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа Засгийн газрын тохируулагч агентлаг, Хил хамгаалах ерөнхий газар болон өөрчлөгдөн зохион байгуулагдаж ирсэн түүхтэй.

Ингэж бүтцийн өөрчлөлт хийж байсан нь Хилийн цэргийн байгуулалт, бүтэц, орон тоо өөрчлөгдөж улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, зарим үед буурах явдалд хүргэж байсан болно.

Гурав.Хилийн цэргийн байгуулалтын өнөөгийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлүүд:

Төрийн батлан хамгаалах бодлого, цэргийн номлол нь төрөөс улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт

байдал, газар нутаг, хил хязгаарын аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндэс болж байна.

Дэлхийн улсууд XX зуун, XI зууны эхэн үеийн цэрэг улс төрийн нөхцөл байдал, бүрэн эрхт байдлаа батлан хамгаалах хэрэгцээ шаардлага, өөрийн улсын улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг техникийн, хууль зүйн нөхцөл байдлыг уялдуулан цэргийн байгуулалтаа улам бүр төгөлдөржүүлсээр байна.

Өндөр хөгжилтэй зарим улсын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний тоог авч үзвэл хуурай замын цэрэг нь нийт бие бүрэлдэхүүний 70 гаруй хувийг, агаарын цэргийн хүчин нь 15,0 хувийг, тэнгисийн цэргийн хүчин 13,0 хувийг эзэлдэг ерөнхий хандлага байгаа бөгөөд харин цэргийн төсвийн зардлын 40,0 хувь нь хуурай замын цэрэг, 33,0 хувь нь агаарын цэргийн хүчин, 27,0 хувь нь тэнгисийн цэрэгт ноогддог байна.

Сүүлийн үед АНУ сансар-огторгуйн бие даасан зэвсэгт хүчинтэй болж, ОХУ нь ийм төрлийн зэвсэгт хүчинтэй болохоо зарлаад байна.

Эдийн засгийн хүчирхэг 10 улсын цэргийн зардлыг авч үзвэл эдгээр улсууд зэвсэгт хүчин, цэргийн байгуулалтдаа дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 3,3 хувийг зарцуулж (Турк, Хятад 4,6 хувиар тэргүүлж, Япон-Канад 1,0-2,0 хувийн бага үзүүлэлттэй байна), нэг цэргийн албан хаагчид оногдох зардал улс бүрд харилцан адилгүй байна. Жишээ нь: Канадад хамгийн их буюу 184 мянган доллар, Туркт хамгийн бага буюу 8 мянган доллар, улс орнуудын дундаж нь 90 мянган доллар байна'.

Батлан хамгаалах зардал нь дотоодын нийт бүтээгдэхүүний 6-7

хувиас илүүгүй байх нөхцөлд нийт хүн амынхаа 1,0 хувиас илүүгүй тооны бие бүрэлдэхүүнийг зэвсэгт хүчиндээ барьж байх боломжтой гэж үздэг. Гэхдээ зэвсэглэл, техник худалдан авах зардал батлан хамгаалах нийт зардлын 26 хувиас багагүй, цэргийн эрдэм шинжилгээ судалгааны зардал 10 хувиас багагүй байх ёстой гэж үздэг байна.

Монгол Улсын батлан хамгаалах зардал нь дээрх орнуудын дунджаас доогуур байгаа болно. Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс нутгийн төлөө байж, үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах, хөрш орнууд, бусад оронтой харилцан эрх тэгш хамтын ажиллагаагаар энхийг эрхэмлэх гадаад бодлого явуулан цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байгаа.

Гэвч цэргийн түрэмгийлэл, заналхийллийн эсрэг бэлтгэлтэй байж, цэргийн аюулгүй байдлыг бүх талаар хангах нь батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтуудын тулгуурлан цэргийн байгуулалтаа улам боловсронгуй болгох асуудал нь чухал байна.

XX зуун нь улс орнуудын батлан хамгаалах, аюулгүй байдлаа хангах бодлого, стратеги, цэргийн байгуулалтын онол, практикийн асуудлыг шалгасан, бас хөгжүүлсэн, дэлхийн хүчний тэнцвэртэй байдлыг бий болгохыг зорьсон дайн, зэвсэгт тэмцэл, батлан хамгаалах аюул занал, сөргөлдөөний зуун байв.

Дэлхийн II дайн нь цэргийн шинжлэх ухаан түүний судлах зүйл болох цэргийн урлаг, түүний дотор цэргийн байгуулалтад хүчтэй нөлөө үзүүлсэн болно.


Дэлхийн II дайны төгсгөлийн шатанд Японы түрэмгийлэгч (империалистууд)-ийг бут цохих чөлөөлөх дайнд хилийн цэргийн үндсэн хүч хэрэгсэл, тэдгээрийн дотроос Дорнод, Дорноговь аймгуудад байрлаж дугаар отрядууд оролцож, Зөвлөлт Монголын цэргийн ерөнхий давшилтын тодорхой чиглэл хэсэгт толгойн сэргийлэхэд үүрэг гүйцэтгэх, гол чиглэлд цохилт өгөх, дайсны сарнисан хэсэг бүлгийг устгах, олзлогдогсдыг харгалзах, хуяглан хүргэх болон бусад олон чухал үүргүүдийг гүйцэтгэсэн болно.

Энэ дайнаар хилийн отряд, застав тэдгээрээс бий болгосон

бүлэглэлүүд байлдааны асар их туршлага хуримтлуулж, байлдааны цагийн байдалд нийцсэн зохих хүч хэрэгсэлтэй байх нь чухал болохыг хожим нь хилийн цэргийн байгуулалтын бүтэц зохион байгуулалтад тусган хэрэгжүүлсэн билээ.¹

Тайван цагт дайн, байлдааны бэлтгэлийг хангах нь туйлын чухал болохыг нотлон харуулсан, төдийгүй байлдааны ажиллагааны (дайны явцын) туршлага сургамжийг үнэлэн цэгнэх, цэргийн урлагийг хөгжүүлэх, цэргийн бодлого, стратегийн байгуулалтыг төгөлдөржүүлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрүүлсэн түүхэн үйл явдал болсон гэж үздэг.

Зураг 1.Хилийн цэргийн байгуулалтын бүрэлдэхүүн



Цэргийн байгуулалтыг (хилийн цэргийн байгуулалт) бэхжүүлэх, үндсэн үүргийг тодорхойлоход зайлшгүй харгалзан үзэх хүчин зүйлс. Үүнд: ²

-Цэргийн аюул, занал, эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг тогтмол тодорхой хугацаанд хийж байх;

-Цэрэг, батлан хамгаалахын бодлого, үндсэн чиглэлийг тогтоох, тодотгох;

-Батлан хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэж үйлчлэх хууль зүйг бий болгох;

-Цэргийн хэрэгцээт зэвсэглэл, техник, эд хөрөнгийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг бэхжүүлэх;

-Улс орны эдийн засаг, хүн амын нөөц, дайчилгааны бэлтгэл, зэвсэгт хүчин хилийн ба дотоодын цэрэг онцгой байдлын байгууллагын удирдлагын тогтолцоог бий болгох, төлөвшүүлэх;

¹ А.Энхтөр, Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал. УБ., 2022. 76 дахь тал

² Ц.Дашзэвэг, Ш.Паламдорж, "Батлан хамгаалах" болон "Цэргийн стратеги". УБ., 2017. 48 дахь тал.

-Дайчилгааны (улсын) нөөцийг бий болгох, бүрдүүлэх, орон нутгийн болон иргэний хамгаалалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

-Улсыг батлан хамгаалах арга хэмжээ, эрх ашигт нийцүүлэн газар орныг төхөөрөмжлөх, цэргийн дэд бүтцийг байгуулах, хил орчмын нутаг дэвсгэрийн дэд бүтцийг бий болгох;

-Эх орноо батлан хамгаалахад чиглэсэн цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх;

-Иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, сургалт, хүмүүжил, сурталчилгааны тогтолцоо бий болгох;

-Цэргийн зардал, батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, санхүүжүүлэх;

-Олон улсын цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлуудыг цогцоор нь авч үзэж, цэргийн байгуулалтын тогтолцооны хамрах хүрээнд хэрэгжүүлж байх шаардлагатай.

Цэргийн байгуулалтын (хилийн цэргийн байгуулалт) онол-практик томоохон дайн, байлдааны ажиллагаа, цэргийн аюул занал нөлөөлөөд зогсохгүй дараах хүчин зүйлүүд улс орнуудын хилийн нөхцөл байдалд ч шууд ба шууд бусаар нөлөөлөх нөлөөлөл нь улам бүр тодорхой болж байна. Үүнд:

1.Дэлхий дахин, бүс нутагт гарч буй цэрэг, улс төрийн нөхцөл байдал. Дэлхийн II дайнаас хойш АНУ-Вьетнам, хоёр Солонгосын дайн, Хятад-Вьетнамын мөргөлдөөн, Ойрхи Дорнод, АНУ-Иракийн дайн, Афганистан, ОХУ дахь дотоодын дайн самуун, БНАСАУ, Ираны цомийн ЗЭВСЭГЛЭЛ Зүүн хойд Азийн аюулгүй байдал, Хятад-Америкийн өмнөд далан дахь сөргөлдөөн, Израйль-Палестины зөрчилдөөн, Англи, Аргентин Фольклендийн арлууд дахь үйл явдал зэрэг болно.¹

2.Дэлхийн бүс нутгийн орнуудын хоорондын болон дотоод улс төр цэрэг, шашин, үндэстний зөрчилдөөний байдал. XX зууны төгсгөлд Европ, Азийн зарим улс оронд өрнөсөн Ардчилал өөрчлөн байгуулалтын явцын үр дүнд дэлхийд бие даасан тусгаар улсууд шинээр бий болсон. ЗХУ, ХБНГУ, Чехословак гэх мэт улсууд задарч, Варшавын гэрээний орнууд үгүй болсон. НАТО-нь зүүн Европ руу түүний дотор ОХУ руу хүрээгээ тэлсэн.

3.Цэрэг дайны уламжлалт онолд зарчмын чанартай орсон өөрчлөлт, хамтын аюулгүй байдлыг хангах үзэл номлол. НҮБ-ын гүйцэтгэх үүрэг роль өсөн нэмэгдсэн, олон улсын терроризм үүссэн, иргэний дайн, байлдаан тухайн улс орны хяналтаас алдагдах, энхийг сахиулах ажиллагаа өргөжин тэлсэн, дайн нь эрлийзжсэн, цахимжсан, мэдээллийн, худалдааны, шашны, үзэл суртлын, терроризм, эдийн засгийн гэх мэт төрөл зүйлд хөрвөж, тэдгээртэй тэмцэхэд улам бүр хэцүү болоход хүргэсэн.

4.Улс орон, бүс нутаг, дэлхий дахиныг хамарсан байгалийн давагдашгүй хүчин зүйлс, хууль бус цагаачлал, дүрвэгсэд, өвчин тахал, технологийн эвдрэл (байгаль) экологийн сүйрэл. Жишээ нь: Японы цунами, газар хөдлөлт, БНХАУ, Энэтхэгийн үер усны аюул, Австралийн гал түймэр, Сири дахь дүрвэлт, АНУ-д цагаачлал, ЗХУ-д Чернобылийн атомын цахилгаан станцын сүйрэл гэх мэт.

5.Улс орон, дэлхий, бүс нутгийг хамарсан эдийн засгийн хямрал. 2009 оны дэлхийн эдийн засгийн хямрал, 2020 оны Коронавируст халдвараас үүдэлтэй эдийн засгийн уналт, зогсонги байдал, доллар, юанийн ханшийн өөрчлөлт, санхүүгийн зах зээлийн сул хөгжил, ажилгүйдэл, ядуурал.

6.Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны төлөөх тэмцэл, мөргөлдөөн БНХАУ (Хонконг, ШУӨЗО), АНУ (арьсны

¹ Дайн, дайны тухай судалгаа лавлагаа. УБ., 2015. 1-2 дахь тал

өнгөөр ялгаварлахын эсрэг)-ын улс төрийн эрх, эрх чөлөө, Африкийн өнгөт хувьсгал, Украины тусгаар тогтнол, бие даасан байдлын төлөөх хувьсгал тэмцэл.

7.Улс орнуудын дотоод дахь улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүй, цэрэг-иргэний тогтворгүй байдал, тэмцэл мөргөлдөөнөөс үүдэлтэй хурцадмал байдал. (жагсаал цуглаан, мөргөлдөөн, дүрвэлт, төрийн эргэлт гэх мэт)

8.Геополитик буюу газар зүйн байршлаас үүдэлтэй ашиг сонирхол, сансар огторгуй бөмбөрцгийн туйлууд дахь орон зайн өрсөлдөөн тэмцэл. АНУ, ОХУ, БНХАУ-ын сансар огторгуйн эзэмшил, цаашдын хандлага, Япон, ОХУ-ын Курилын арлуудын сэргөлдөөн, АНУ, БНХАУ-ын Өмнөд далай дахь арлын төлөөх зөрчилдөөн, ОХУ-ын өмнөд, хойд туйлын стратегийн хяналт, ашиг сонирхол болон хүн ам, газар нутаг, хүчин чадал бүхий улс гүрнүүдийн шахалт, хориг арга хэмжээ, дэлхийн зах зээлийн орон зайн төлөөх сэргөлдөөнөөс үүдэлтэй бусад хүчин зүйлүүд нь аливаа улс орнуудын цэрэг-зэвсгийн хөгжил, цэргийн урлаг, байгуулалтад шууд ба шууд бусаар нөлөөлсөөр байна.

Эдгээр хүчин зүйлүүдээс аливаа улс орны цэргийн байгуулалтад зэвсэгт хүчний байгуулалтыг нөлөөлөх стратегийн үнэлгээ хийж, хөгжүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх шийдвэр гаргадаг байна.

Хилийн цэргийн байгуулалтад нөлөөлөх хүчин зүйлс, түүнийг гадаад дотоод гэж ангилдаг. Үүнд:

а.Гадаад хүчин зүйл

-Дэлхий дахин, бүс нутаг, хөрш улсуудын улс төр, нийгэм-эдийн засаг

-Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа

-Шинжлэх ухаан, техникийн хөгжил

-Геополитик буюу газар зүйн байршлаас үүдэлтэй ашиг сонирхол

-Хууль эрх зүй

-Хил хамгаалалтын стратеги, тактик

-Олон улсын гэрээний хэрэгжилт

б.Дотоод хүчин зүйл

-Улс төр

-Нийгэм-эдийн засаг

-Хууль эрх зүй

-Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа

-Хилийн аюулгүй байдал гэх мэт...

Хилийн цэргийн байгуулалтын өнөөгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд:

Давуу тал (strengths):

1.Зорилго, зорилт тодорхой, хуулиар баталгаажсан;

2.Олон жилийн байгуулалтын түүхтэй, уламжлалтай;

3.Ажлын байрны нөхцөл, мэдээллийн боломж сайн;

4.Санхүүжилтийн зарчмыг зөв шийдсэн, цалин, хангалт цагтаа хийгддэг; боловсон хүчнээ бэлтгэх;

5.Мэргэжлийн боловсон хүчинтэй, мэргэжлийн сургуультай;

6.Жил бүр гадаад, дотоодод богино болон урт хугацааны сургалтад албан хаагчдыг сургаж, боловсон хүчнээ мэргэшүүлж байна;

7.Хамт олны уур амьсгал хэвийн, санал гомдолд хянамгай хандаж шийдвэрлэдэг;

8.Байгууллагын талаар иргэдийн ойлголт харьцангуй сайн, нэр хүнд сайтай, ажиллагсдын нийгмийн асуудал, эрүүл мэндэд анхаардаг тул тус албанд ажилд орох сонирхол нийгэмд нэмэгдсэн.

Сул тал (weaknesses):

1.Хил хамгаалах урлаг, онолын түвшинд хөгжилт, хэрэгжүүлэлт зогсонги байдалд орсон;

2.Хил хамгаалалтын шууд ба шууд бус зардлын зохистой харьцаа алдагдсан;

3.Эрдэмтэн судлаачид болон мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, хил хамгаалалт, хилийн аюулгүй байдлын судалгаа хийх Дотоод хэргийн

их сургуультай харилцаа, хамтын ажиллагаа хангалтгүй;

4.Зарим мэргэжлийн стандарт байхгүй, мэргэжилтнийг бэлтгэх бодлого сул;

5.ХХБ-ын бүтэц, орон тоо нь хилийн нөхцөл байдал, физик газар зүйн онцлог, сүүлийн арван жилд батлагдан гарсан хууль тогтоомжтой нийцээгүй;

6.Зэвсэг техник, цэргийн дүрэмт хувцаснаас бусад төвлөрсөн хангалтын тогтолцоо доголдсон, алба хаах нөхцөл орчноо сайжруулахын тулд улсын хил хамгаалалтын үндсэн үүргээ орхин дулааны улиралд аж ахуйн аргаар, дотоод орлогоороо барилгын ажил хийдэг зэрэг нь нөлөөлж байна.

Дүгнэлт



Санал

Дэлхий дахин, бүс нутгийн цэрэг улс төрийн нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн боломж, физик газар зүйн онцлогийг харгалзан, Хил хамгаалах байгууллагын бүтэц орон тоог өргөтгөн, бүсүүдийн удирдах газрыг байгуулах;

Хөгжингүй болон хөрш орнуудын хил хамгаалалтад ашиглагдаж буй техник технологийн ололтыг улсын хил хамгаалалтад үе шаттайгаар нэвтрүүлэх, ашиглах;

Агаар мандал болон газрын хэвлийн хилийн асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчинг сайжруулж, техник технологийг хөгжүүлэхэд анхаарах;

Зэвсэгт хүчинд цэргийн байгуулалтын онол жинхэнэ утгаараа хэрэгжиж байгаа бөгөөд хилийн цэрэг нь ердийн болон хилийн цагийн байдал хүндэрсэн үед хилийн цэргийн байгуулалтын тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, түүний нөхөн хангалт, нэгжүүдийн уялдаа холбоо, зэвсэглэл, техникийн хангалт, цэргийн алба хаах, боловсон хүчнийг бэлтгэх, хүч хэрэгслийг байршуулах, нөөцүүдийг бүрдүүлж ашиглах, анги, салбарын байнгын бэлэн байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулж байгаа ба түүнийг цэргийн байгуулалтын онолын түвшинд илүү боловсронгуй болгон хөгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.



Бие бүрэлдэхүүний ихэнх нь залуу, дунд үе учраас оюуны хөрөнгө оруулалтыг хийн гадаад хэлний мэдлэгийг нь дээшлүүлэх;

Бүх төрлийн нөөцийг оновчтой, зөв менежментээр удирдан зохион байгуулж, өндөр үр дүнд хүргэх зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт:

- Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс, УБ., 2015 он.

- Бүсчилсэн хамгаалалтын хөтөлбөр (2008-2012). УБ., 2008 он

- Наранжамц Н., Улсын хил хамгаалалтын онол-практикийн үндсэн асуудал. УБ., 2008 он

- Монгол Улсын хил
хамгаалалтын түүх I боть. УБ., 2008 он

- Монгол Улсын хил
хамгаалалтын түүх II боть. УБ., 2008 он

- Дашзэвэг Ц., Паламдорж Ш.,
“Батлан хамгаалах” болон “Цэргийн
стратегийн”. УБ., 2017 он

- Дашзэвэг Ц., Паламдорж Ш.,
Цэргийн нэр томъёоны тайлбар толь.
УБ., 2014 он

- Энхтөр А., Монгол Улсын хилийн
цэргийн байгуулалтын онол, практикийн
асуудал УБ.,
2022 он